

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Тариалан Нийтийн Ахуй Үйлчилгээ” ХХК -ийн 2025 оны санхүүгийн тайлан,
тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан.

Аудитын код: ХӨА-2026/026/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн захирал:
Д.Мягмарсүрэн
Утас: 99030170, Цахим хаяг: dalaivan.et@gmail.com

Бэйкир Тилли Далайван аудит ХХК-ийн аудитор:
Б.Пүрэвсүрэн
Утас: 99921600, Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 01/296
танай _____-ны № _____-т

“ТАРИАЛАН НИЙТИЙН АХУЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.ДАВААБААТАР ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд аудит хийлээ.

“Тариалан нийтийн ахуйн үйлчилгээний төв” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 7,000.00 мянган төгрөгийн тэлэлтийн савыг үнэ төлбөргүй авч, 96,000.0 мянган төгрөгийн халаалтын тогооны 36,000.0 мянган төгрөгийг хандиваар, 60,000.0 мянган төгрөгийг буцаан төлөх нөхцөлтэй зээлийн гэрээ байгуулан авч бүртгэлд тусгасан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар 106,618.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 105,395.6 мянган төгрөгийн, төсвийн зарцуулалттай холбоотой 1,222.9 мянган төгрөгийн зөрчилд холбогдох шийдвэрийг гаргаж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 41 арга хэмжээтэй хэрэгжүүлэхээр төлөвлөж, 95.1 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,610,810.60	1,216,574.17
1.1.2	Дансны авлага	62,113,341.90	193,534,109.85
1.1.6	Бараа материал	97,492,281.09	108,233,713.44
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	161,216,433.59	302,984,397.46
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,272,113,418.26	1,288,693,049.99
1.2.2	Биет бус хөрөнгө	22,171,720.00	22,171,720.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,294,285,138.26	1,310,864,769.99
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,455,501,571.85	1,613,849,167.45
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	107,615,806.71	204,848,025.14
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	51,444,073.84	82,223,000.28
2.1.1.4	НДШ - ийн өглөг	0.00	18,417,047.34
2.1.1.5	Хойшлогдсон татварын өглөг	45,903,874.29	45,903,874.29
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	26,877,758.71
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	204,963,754.84	378,269,705.76
2.2	Өр төлбөрийн нийт дүн	204,963,754.84	378,269,705.76
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	367,132,300.00	367,132,300.00
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- Хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	635,114,945.95	635,114,945.95
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	463,112,399.00	506,112,399.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(214,821,827.94)	(214,821,827.94)
2.3.10	Тайлант үеийн ашиг	0.00	(57,958,355.32)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	1,250,537,817.01	1,235,579,461.69
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	1,455,501,571.85	1,613,849,167.45

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,016,488,522.62	1,062,429,130.57
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	951,754,997.42	1,012,230,644.62

3	Нийт ашиг (алдагдал)	64,733,525.20	50,198,485.95
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	0.00	0.00
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	0.00	0.00
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	85,450,314.00	92,211,872.07
11	Санхүүгийн зардал	0.00	103,223.47
12	Бусад зардал	0.00	15,314,909.09
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	8,921,537.84	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(29,638,326.64)	(57,431,518.69)
19	Орлогын татварын зардал	0.00	526,836.63
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(29,638,326.64)	(57,958,355.32)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(29,638,326.64)	(57,958,355.32)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Үнэ төлбөргүй/өөрийн хөрөнгөөр	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(29,638,326.64)	(57,958,355.32)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,090,176,541.79	1,106,790,122.74
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,090,176,541.79	1,062,623,750.11
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
	Татаас, санхүүжилтын орлого	0.00	0.00
	Бусад мөнгөн орлого	0.00	44,166,372.63
1.2	Мөнгөн зарлага (-)	996,490,197.66	1,070,184,359.17
	Ажиллагчдад төлсөн	280,340,132.06	313,509,542.96
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	82,480,205.35	78,756,926.89
	Бараа материал худалдан авахад төлсөн	151,129,713.00	202,766,319.00
	Ашиглалтын зардалд төлсөн	114,981,479.53	126,381,027.26
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	279,584,565.50	234,085,836.50
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	46,963,025.25	48,909,121.17
	Даатгалын төлбөрт төлсөн	61,425.00	0.00

	Бусад мөнгөн зарлага	40,949,651.97	65,775,585.39
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	93,686,344.13	36,605,763.57
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	9,411,888.00	0.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	9,411,888.00	0.00
	Хүлээн авсан хүүний орлого	0.00	0.00
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	95,487,500.00	30,000,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	95,487,500.00	30,000,000.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(95,487,500.00)	(30,000,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	9,411,888.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	9,411,888.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	14,211,888.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	9,211,888.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахал төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	5,000,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,800,000.00)	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(6,601,155.87)	6,605,763.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,211,966.47	1,610,810.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,610,810.60	1,216,574.17

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2024 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.95	375,662,399.00	(180,183,501.29)	1,197,726,143.66
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(29,638,326.64)	(29,638,326.64)

Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	(5,000,000.00)	(5,000,000.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	87,450,000.00	0.00	87,450,000.00
2025 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.95	463,112,399.00	(214,821,827.93)	1,250,537,817.02
Дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00	43,000,000.00	0.00	43,000,000.00
2025 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	367,132,300.00	635,114,945.95	506,112,399.00	(214,821,827.93)	1,293,537,817.02

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төгрөгөөр

№	Үзүүлэлт	2025 оны төлөвлөгөө	2025 оны гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин	391,748,166.00	388,423,095.07	3,325,070.93	99.15
2	НДШ	48,900,159.00	53,805,443.74	(4,905,284.74)	110.03
3	Болзошгүй зардал	6,200,000.00	1,320,000.00	4,880,000.00	21.29
4	Тэтгэврийн тэтгэмж	22,737,078.00	15,679,902.00	7,057,176.00	68.96
5	ТУЗ-н зардал	4,700,000.00	1,749,450.00	2,950,550.00	37.22
6	ТУЗ-н НДШ	506,000.00	218,681.25	287,318.75	43.22
7	Төлбөр хураамж	10,034,000.00	103,223.47	9,930,776.53	1.03
8	Нүүрсний зардал	118,244,000.00	122,615,379.00	(4,371,379.00)	103.70
9	Нүүрс тээврийн зардал	248,517,881.63	198,793,274.09	49,724,607.54	79.99
10	Түлээний зардал	3,390,000.00	1,951,600.00	1,438,400.00	57.57
11	Хор саармагжуулах зардал	4,500,000.00	1,590,901.11	2,909,098.89	35.35
12	Урсгал зардал	11,005,000.00	28,923,543.83	(17,918,543.83)	262.82
13	Хөдөлмөр хамгаалал	17,679,700.00	8,416,590.96	9,263,109.04	47.61
14	Бичиг хэргийн зардал	1,397,500.00	654,545.45	742,954.55	46.84
15	Сан ба сэлбэгийн зардал	21,687,500.00	7,620,454.55	14,067,045.45	35.14
16	Цэвэрлэгээний зардал	7,911,000.00	3,190,909.09	4,720,090.91	40.34
17	Үйлчилгээний тохижилт	4,115,000.00	2,594,041.09	1,520,958.91	63.04
18	Шатахууны зардал	31,553,800.00	28,079,375.94	3,474,424.06	88.99
19	Шуудан холбооны зардал	2,748,000.00	2,154,746.08	593,253.92	78.41
20	Ажилчдын нийгэм ханамж	16,350,000.00	15,096,227.84	1,253,772.16	92.33
21	Цахилгааны зардал	167,656,438.40	141,196,388.42	26,460,049.98	84.22
22	Элэгдэл	90,048.81	93,962,868.26	(93,872,819.45)	
23	Томилолтын зардал	1,945,000.00	1,020,000.00	925,000.00	52.44
24	Орлогын албан татварын зардал		526,836.63	(526,836.63)	
25	Программын үнэ	2,090,000.00	700,000.00	1,390,000.00	33.49
26	Нийт зардал	1,145,706,271.84	1,120,387,477.87	25,318,793.97	97.79
	Нийт орлого	1,150,706,271.84	1,062,429,130.57	88,277,141.27	92.33
	Татаасын дараах ашиг ,алдагдал	5,000,000.00	(57,958,347.30)	62,958,347.30	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,133.7 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 5,533.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 278.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, материаллаг бус зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, 10,322.1 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг тус тус өгсөн.

Залруулсан алдаа:

- Бараа материалын дансанд 4 963.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 570.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" -ын 6.Бараа материал "Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна" гэсэн заалтууд зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1 Төлбөрийн акт

1. Цалингийн анхан шатны баримт, цалингийн тооцооллыг түүвэрлэн шалгахад цагийн бүртгэлээр бүртгэгдээгүй, ажиллаагүй ажилтны 6 хоногийг ажилласнаар тооцон 278.6 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д "цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, 42 дугаар зүйлийн 42.1.3-т "гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй болон Тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Албан шаардлага.

1. Тайлангийн хугацааны эцэст 17.853.0 мянган төгрөгийн авлага, 1.299.2 мянган төгрөгийн өглөг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" 20 дугаар зүйл Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүрэг 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроож үндсэн хөрөнгө, бараа материалын орлогод авсан тушаал болон тооллогын комиссын тушаал, зэргийг шилэн дансанд байршуулж мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6 дугаар зүйлийн 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасныг хэрэгжүүлээгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй 71 332.6 мянган төгрөгийн анхны өртөгтэй 9 нэр төрлийн 11 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж,

санхүүгийн тайлан гаргах”, ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалт зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх

2. Биет бус хөрөнгийн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн хэмжээ цахим системээс 4738м.кв буюу 9,377.7 мянган төгрөгийн зөрүүтэй /илүү/ бүртгэгдсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1.1 үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх, техник, технологийн баримт бичгийг гүйцэд бүрдүүлсэн байх; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4.үнэн зөв байх, Засгийн газрын 2020 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 10-р тогтоолын 7 дахь заалт зэргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгөд гарсан хөдөлгөөн, өөрчлөлтийг нягтлан бодохын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан байх

3. Цалингийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн тооцооллыг шалгахад НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээр цалин 944.3 мянган төгрөгийн зөрүүтэй НД-ын тайланд үндсэн цалинг илүү тайлагнасан байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1.5-д “цалин хөлсийг тооцох аргачлал ил тод, ойлгомжтой байх, “Нийгмийн даатгалын тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалингийн хүснэгтээрх тооцоолсон дүнг үнэн зөвөөр тайлагнах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2026 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Fas.audit.mn сайтад мэдээлж баталгаажуулна уу.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Завсрын аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Залруулга	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн бүртгэл дутуу, хөрөнгийг бүртгэсэн коджуулалт хийгдээгүй,эд хариуцагчийн карт шинэчлэгдээгүй байна.	1	-							1	-
Шатахууны тендерийн материал шаардлага хангахгүй байна.	1	62,052.4					1	62,052.4		
баримт шаардлага хангахгүй байна.	1	1,794.8					1	1,794.8		
биет бус хөрөнгийн дансанд байгаа газар эзэмших эрхийн зөрүүтэй	1	2,144.3					1	2,144.3		

Тухайн байгууллагад шатахууны тооцооны хуудас байхгүй, тооцоолол байхгүй байна.	1	1,065.0					1	1,065.0		
Өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй.	1	152,901.6					1	152,901.6		
Татварын тайланд орлого дутуу тайлагнасан	1	61,554.8							1	61,554.8
Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроож тушаал шийдвэр байршуулаагүй	1	-					1	-		
Нийт дүн	8	281,512.9					6	219,958.1	2	61,554.8

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
							Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансанд 4 963.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 570.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил бүртгэлтэй байна.	1	5,533.1			1	5,533.1	1	5,533.1
Дүн	1	5,533.1			1	5,533.1	1	5,533.1

Хүснэгт №-6. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өр төлбөр үүсгэсэн	1	-					1	-
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн тэг үлдэгдэлтэй	1	-			1	-		
Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй газар эзэмших эрхийн хэмжээ цахим системээс 4738м.кв буюу 9 377.7 мянган төгрөгийн зөрүүтэй /илүү/ бүртгэгдсэн байна.	1	9,377.7					1	9,377.7
ажиллаагүй ажилтны 6 хоногийг ажилласнаар тооцон 278.6 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна.	1	278.6	1	278.6				
НД-ын тайланд тайлагнасан цалин, цалингийн хүснэгтээрх цалин 944.3 мянган төгрөгийн зөрүүтэй	1	944.3					1	944.3
Дүн	5	10,600.6	1	278.6	1	-	3	10,322.1

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн нийцлийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансанд 6 мэдээ хугацаа хоцроож тушаал шийдвэрийг мэдээлээгүй байна.	1	-			1	-		
Нийт дүн	1	-	-	-	1	-		

